



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 9/21

Улаанбаатар хот


Ажлын хэсэг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, нийслэлийн Онцгой байдлын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг удирдан, зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (дэд хурандаа Б.Баттулга)-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баттулга Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа

Гишүүд:

Ж.Төмөрмандах Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, гамшгийн эрсдэлийн
удирдлагын тасгийн дарга, хошууч,

Д.Оюунбат Нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд
хурандаа,

Б.Чинбат Гамшигаас урьдчилан сэргийлэх хэлтсийн Сургалт сурталчилгаа,
урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд
хурандаа,

Ж.Алтанхуяг Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Сургалт, гал түймэр унтраах
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Ц.Чинзориг Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, гамшгийн эрсдэлийн
удирдлагын тасгийн Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан
ахлах мэргэжилтэн, ахмад,

Э.Пүрэв-Очир Захиргааны удирдлагын хэлтсийн Хуулийн зөвлөх, өргөдөл гомдол
хариуцсан ахлах мэргэжилтэн,


Б.Батболд Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ, гамшгийн эрсдэлийн
удирдлагын тасгийн Дотоод, хяналт, шинжилгээ, үнэлгээ, ёс зүйн
асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад,

Нарийн бичиг:

Р.Мөнхбат Захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод ажил, төлөвлөлт хамтын
ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч

---оо---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
12-дугаар тушаалын хөёрдугаар хавсралт



**“НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ”-ИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хяналт тавьж ажиллах албан тушаалтан
1.	“Нийслэлийн Онцгой байдлын газрын дүрэм”-ийн төслийг боловсруулах	3 дугаар сарын 06-13	Ажлын хэсэг	Дэд хурандаа Н.Нямхорлоо
2.	“Нийслэлийн Онцгой байдлын газрын дүрэм”-ийн төслийг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулж санал авах	3 дугаар сарын 13-15	Дэд хурандаа Б.Баттулга	Дэд хурандаа Н.Нямхорлоо
3.	Дүрмийн төслийг Онцгой байдлын ерөнхий газрын холбогдох албан тушаалнуудад танилцуулж санал авах	3 дугаар сарын 19-20	Дэд хурандаа Б.Баттулга	Дэд хурандаа Н.Нямхорлоо
4.	Дүрмийн төслийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд танилцуулж санал авах	3 дугаар сарын 20-21	Дэд хурандаа Б.Баттулга	Дэд хурандаа Н.Нямхорлоо
5.	Саналуудыг авч нэгтгэн дүрмийн төсөлд тусгаж дахин боловсруулан хянуулж даргын зөвлөлийн хуралд танилцуулж хэлэлцүүлэх	3 дугаар сарын 21-25	Дэд хурандаа Б.Баттулга	Дэд хурандаа Н.Нямхорлоо
6.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулах	3 дугаар сарын 25	Дэд хурандаа Б.Баттулга	Дэд хурандаа Н.Нямхорлоо

---оо---